



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХӨВСГӨЛ ХҮНС ХУВЬЦААТ
КОМПАНИ**

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2534

Талбай 2025.09.30 № 27

Талбай -ны № _____ -т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-Д

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
мэдэгдэл хүргүүлэх тухай

Манай "Хөвсгөл Хүнс ХКомпанийн
2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний
өдрийн 17:00 цагт болохоор ТУЗ-ийн
шийдвэр гарсаныг үүгээр хүргүүлж байна.



ЗАХИРАЛ *Ж.НАЦАГБАДАМ*

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны
 өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн
 хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр хэвсрэлт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Хөвсгөл Хүнс" ХК
Хаяг, утас:	Хөвсгөл аймаг мөрөн сум 8-р баг
Хурал хуралдах өдөр, Цаг:	2025.04.29-ны 17.00 цагт
Хурал хуралдах газар/ хаяг, байршил /:	"Хөвсгөл Хүнс" ХК-ийн хурлын зааланд Хөвсгөл аймаг Мөрөн сум 8-р баг
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025.03.20
Олон нийтэд зарлах огноо:	2025.03.25
Бүртгэлийн өдөр:	2025.04.14
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, диллерийн компанид хүргүүлэх огноо:	2025.03.31
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	Л.ДАШЦЭРЭН
Тослогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: Ж.Алтангэрэл гишүүд: Б.Дашзэвэг Т.Бяибажаргал
Баримт, бичгийн жагсаалт /хэвсрэлтээр/	
Баримт, бичгийн хуудасны тоо:ширхэгхуудас

ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН

ДАРГА



/Л.ДАШЦЭРЭН /

2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
"ХӨВСГӨЛ ХҮНС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 он 03 сар 20 өдөр

№03


Мөрөн хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хуралхуралдуулах тухай

Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн Тогтоох нь:

- Хүнс үйлдвэрлэл, барилга угсралт, худалдаа үйлчилгээний "Хөвсгөл Хүнс" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дугаар сарын 29-ний 17.00 цагт Хөвсгөл аймгийн мөрөн сумын 8-р багт байрлах "Хөвсгөл Хүнс" ХК-ийн хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
 - Компанийн 2024 оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - 2024 оны Хянан шалгах зөвлөлийн тайлан
 - Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг батлах
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
 - ТУЗ сонгох
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 14 -ны өдрөөр тогтоосугай.
- Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөрт багтаан өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02-р хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 9:00-17:00 цагийн хооронд "Хөвсгөл Хүнс" ХК-ийн байранд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/С.Отгонбаатар/-с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
- Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ынагуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.

- Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Дашцэрэн, тооллогын комиссын даргаар Ж.Алтангэрэл гишүүдээр Б.Дашзэвэг, Т.Бямбажаргал нарыг тус тус томилсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга  Л.Дашцэрэн

